

ЭРДЭМТЭН СУДЛААЧИД, ӨРГӨН ОЛНЫ СОНОРТ

Сүүлийн үед судалгаа шинжилгээний олон арван шинэ бүтээл гарч судалгааны эргэлтэнд орсоор байна. Гагцхүү дотоод, гадаад гарсан шинэ бүтээлийн талаар мэдээлэл туйлын хомс, хаана юу гарсан нь тэр бүр мэдэгдэхгүй байна. Манай дотооддоо санхүүгийн боломжоос хамааран цөөн тоогоор хэвлэгдэх болжээ. Энэ бүхнийг бодолцон өөрсдийн боломж, гарын дор орж ирсэн бүтээлийн талаар чадвал шүүмж, эс чадвал танилцуулга бичиж өргөн олонд сурталчилж байх нь нэн хэрэгтэй юм. Өрнөдийн эрдэмтэд өөрсдийн бүтээлээ холбогдох эрдэмтэд, судалгааны байгууллагад бэлэглэж шүүмж бичүүлдэг уламжлалыг ч авууштай санагдана. Энэ ажлын эхлэл болгож гарт орж ирсэн хэдэн номын танилцуулгыг уншигчдад толилуулав.

Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний
ахлах ажилтан, доктор (PhD) Ц.БААТАР

Б.БАЛДОО, С.ДАМДИНСҮРЭН, Л.ХАЙСАНДАЙ **“МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ БА ОРОС, ХЯТАДЫН ХҮЧИН ЗҮЙЛ”. УБ., 1999 ОН**

Монголын гадаад бодлого, гадаад харилцааны чиглэлээр дагнан мэргэшсэн манай нэртэй эрдэмтэн, судлаачдын хамтын хүчин чармайлтаар туурвисан энэхүү чамбай бүтээлийг “Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйл” төслийн хүрээнд бичсэн байна. Энэ бүтээл “Богд хаант Монгол Улс ба Орос, Хятадын их гүрний бодлого” гэсэн тэргүүн бүлэг, “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хандлага” гэсэн дэд бүлэг, “Өдгөөгийн монголын гадаад орчин ба Орос, Хятадын хүчин зүйл” гэсэн 3 бүлгээс бүрдэнэ.

Тэргүүн бүлгийг академич Б.Балдоо, дэд бүлгийг доктор С.Дамдинсүрэн, гутгаар бүлгийг доктор Л.Хайсандай нар туурвиж, академич Б.Балдоо хянан тохиолдуулжээ.

Хамтын бүтээлийн тэргүүн бүлэг “Богд хаант Монгол Улсыг тунхагласан нь. Орос, Хятадын бодлого”, “Монголын олон улсын эрх зүйн статусыг тогтоох асуудал. Гурван улсын зарчимт байр суурь”, “Гурван улсын Хиагтын хэлэлцээр. Монголд автономийг тулган хүлээлгэсэн нь”, “Монголын автономи ба Хятадын цэргийн эзлэлт” гэсэн дөрвөн зүйлээс бүрдэнэ.

Академич Б.Балдоо тэргүүн бүлэгтээ: архивын шинэ сурвалжуудыг нягтлан судалж, харьцуулан авч үзээд тухайн үед Оросын засгийн газар Монголын асуудалд хоёр талтай хандсан болохыг тодруулжээ. Энэ нь нэг талаар Хаант Орос Монголд өрнөсөн үйл явдал, буй болсон улс төрийн байдлыг бодитой авч үзэн бүхэлд нь дэмжих; Орос Монголын харилцааг үргэлжлүүлэх, шинээр тогтсон Монголын засгийн газартай холбоо барих; тийм замаар тэндэх байдлыг тайвшуурлан, гарч болзошгүй зэвсэгт мөргөлдөөнийг сэрэмжилж, хэрэв тийм аюул тулгарвал бодитой нөлөөлөх; үүгээр Монгол дахь өөрийн эдийн засаг-худалдааны сонирхлыг хамгаалан, бололцоогоо цааш өргөтгөх зэрэг бодлого баримталж байсан болохыг тодорхой харуулаад Хиагтын гурван улсын хэлэлцээрээр Монголд автономийг тулган хүлээлгэсэн явдал нэг талын нөхцөл болох буюу Хятад, Оросын хүчин зүйлийн харилцан үйлдлийн вектор тодорч тэр нь Хиагтад үсэг зурсан хэлэлцээрээр илрэн гарсан гэсэн дүгнэлт хийжээ. Түүнчлэн Хиагтын хэлэлцээр байгуулагдахаас жил гаруйн өмнө 1914 оны эхээр Төвдийн асуудал шийдвэрлэгдсэн. Энэтхэгийн Дели хотноо Хятад, Англи Төвдийн гурван этгээдийн хэлэлцээ болж түүний дүнд Төвдийг хоёр хувааж, дотоод Төвдийг Хятадын мэдэлд үлдээж, Далай лам тэргүүтэй Гадаад Төвдийг Хятадын сюзеренитет дор орших автономи болгосон хэлэлцээр байгуулж Хятад, Англи, Төвдийн бүрэн эрх барих төлөөлөгчид үсэг зурсан. Төвдийн асуудал шийдвэрлэсэн энэ жишиг Хиагтын хэлэлцээрийн нэг ёсны загвар болсон гэж үзсэн байна.(49 дэх тал)

Академич Б.Балдоо энэхүү бүлэгтээ “1911 онд гарсан монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөл буурлын эгзэгтэй зам туулсан хэдий ч үндсэн зорилтоо шийдвэрлэж, Монгол юугаан бусдын эрхшээлээс гаргаж тусгаар тогтносон улс болгож чадалгүй 10-аад оны эцсээр дарагдав. Гэвч энэ хөдөлгөөн монголын нийгмийн хөрсөнд үр шимээ өгч, ард түмний үндэсний ухамсрыг ихэд сэргээн нийгмийг хөтлөн жолоодох улс төрийн хүчнүүдийг төрүүлсэн ...

Дараалан болсон үйл явдлууд харийн дарлалыг эсэргүүцсэн, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хүссэн тэмцэгчдын шинэ үеийг төрүүлэн гаргах зайлшгүй нөхцөлийг бүрдүүлэхэд тусалсан шимт хөрсийг нь тавьж өгсөн” гэсэн дүгнэлт хийжээ.

Доктор С.Дамдинсүрэн дэд бүлэгтээ: Монгол улсын тусгаар тогтнолын эддрээтэй асуудлыг тал бүрээс нь хөндөн, түүнд Орос, Хятад хоёр хэрхэн хандаж байсныг архивын шинэ баримтыг ашиглан тодорхой гаргаж тавьжээ. Түүнчлэн тэр үеийн Монголын улс төрийн амьдралын онцлогийг нээн харуулсан байна. Зохиогч “энэ үеийн монголын улс төрийн амьдралын нэг онцлог бол нийгэм журам

байгуулах туршилт бүрэн сүйрч Монгол дахь Коминтерний нөлөө бууран, БХХ (б) намын үүрэг, нөлөө өссөн явдал юм.

Монгол улсын хөгжлийн чухал асуудал, улс төрийн бодлогын туламдсан аливаа асуудлаар Монголын нам, төрийн удирдлагууд БХХ (б) Намын Төв Хороо, Зөвлөлт Засгийн газарт ханддаг болж тэдгээрийн заавар зөвлөгөөг авч Зөвлөлтийн бүрэн эрх төлөөлөгч болон сургагч, зөвлөгч нарын удирдлага нөлөөн дор ажиллах болсон юм. Монголын төр нийгэм, эдийн засгийн бодлогын гол чухал асуудлуудыг БХХ (б) Намын Төв Хорооны Улс төрийн Товчоо, түүний дэргэдэх Монголын комисс байнга хэлэлцэн гаргадаг журам тогтсон (81 дэх тал) гэж дүгнэн бичсэн байна. Түүнчлэн өгүүлэн буй үед Монгол орон нэг хэсэг оронтой харилцан хамааралт байдалд хөгжихдөө социализм байгуулах нийтлэг зүй тогтол гэгчээр загварчлагдсан Зөвлөлт маягийн номлолыг дагаж, хувийн өмчийг үгүйсгэсэн, гол түнш социалист орнуудын шинжлэх ухаан техникийн хөгжлийн хүрсэн түвшинг баримжаалснаараа хязгаарлагдмал нөхцөлд орж дэлхийн хөгжлийн нийтлэг хандлагаас хөндийрэх болжээ” гэсэн дүгнэлт хийжээ.

Доктор Л.Хайсандай “Өдгөөгийн Монголын гадаад орчин ба Орос, Хятадын хүчин зүйл” гэсэн гутгаар бүлэгтээ Орос, Хятадын түншлэл ба Монгол орон, Монгол, Оросын харилцааны шинэ хандлага, Монгол, Хятадын харилцааны өрнөлийг Монгол улсын гадаад орчинтой нягт холбон системтэй, эрэмбэ дараатай тоймлон тодорхой харуулаад хөрш хоёр их гүрэнтэй харилцан ашигтай нягт хамтран ажиллах асуудал бол Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашиг байх ёстойг олон талаас нь нягтлан өгүүлсэн байна.

Манайд энэ чиглэлээр бичсэн судалгааны бүтээл цөөнгүй бий. Энэ бүтээл нь урьд өмнөх судалгааны бүтээлүүдэд тэр бүр ороогүй, хуучин тогтолцооны үед хаалттай байсан одоо дөнгөж баримт бичгийн эмхэтгэл хэлбэрээр нийтэд зориулан хэвлэсэн, судалгааны эргэлтэнд ороогүй арвин баялаг материалыг ашиглаж өнөө цаг үеийн өндөрлөгөөс эргэн харж үнэлэлт дүгнэлт өгснөөрөө онцлогтой, маш чухал ач холбогдолтой, үнэ цэнэтэй бүтээл юм.

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд Орос, Хятадын хүчин зүйл урьд ч одоо ч тэргүүлэх зэргийн ач холбогдолтой. Үүнтэй уялдан Орос, Хятадын хүчин зүйлийг юу юунаас чухалчлан үзэж улируулан судлах явдал энэ чиглэлийн судлаачдын эрхэм зорилго байсан цаашид тийм байх бизээ. Жижиг үсгээр шигүү бичсэн нь санхүүгийн талаасаа хэвлэлийн хуудас ихэсгэхгүй сайн тал гэж шүтэж болох боловч уншихад нэлээд хүндрэлтэй харагдана. Үүнийг зохиогчдод зориулаагүй болохыг болгооно бизээ.

Манай нэрт эрдэмтдийн туурвисан энэхүү бүтээл улс төрчид, бодлого боловсруулагчид болон гадаад харилцааны чиглэлийн практик ажилтан, эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн багш, оюутнуудын анхаарал сонирхлыг зүй ёсоор татна гэдэгт найдна.

Г. ТӨМӨРЧУЛУУН.

ПРОЦЕСС ПРИНЯТИЯ ВНЕШНЕ-ПОЛИТИЧЕСКИХ РЕШЕНИЙ В МАЛЫХ ГОСУДАРСТВАХ

(на примере Монголии)

Өнгөрсөн зууны 90-ээд оноос Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын асуудлаар шинэ сэргэг санаа дэвшүүлсэн судалгааны чамбай бүтээлүүд нийтлүүлж олны танил болсон улс төр судлаач, эрдэмтэн, дипломатчидын нэг нь дээрх номын зохиогч Гуудайн Төмөрчулуун юм.

Түүний бичсэн “Жижиг орнуудын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц (Монголын жишээн дээр)” хэмээх нэгэн сэдэвт сонирхол татсан чамбай бүтээлийг Москвагийн “Научная книга” хэвлэлийн газраас 1999 онд 1500 хувь хэвлэн нийтэлжээ. Энэхүү бүтээл өмнөх үг, удиртгал, 6 бүлэг, төгсгөл, хавсралт зэргээс бүрдэнэ.

Зохиогч “Жижиг орнуудын тодорхойлолт, гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц” (онолын үндэслэл) гэсэн тэргүүн бүлэгтээ жижиг орнуудын тодорхойлолт, түүний үндсэн шалгуурт ямар ямар асуудлыг хамруулан авч үзэж буй талаар өрнөдийн эрдэмтдийн онол, гол үзэл баримтлалыг олон улсын харилцааны суурь дэвсгэр дээр системтэй, эрэмбэ дараатай авч үзээд өөрийн үзэл бодлыг илэрхийлжээ.

Дэд бүлэгтээ Монголын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад гадаад орчин тодорхойлогч хүчин зүйл болохыг олон талаас нь нухацтай судалсан байна.

Түүнчлэн их гүрнүүдийн гадаад бодлогод Монгол хэрхэн ямар байдлаар тусч буйг АНУ, ОХУ, БНХАУ-ын жишээн дээр улирлуулан судлаад улмаар Монгол Америк, Монгол Орос, Монгол Хятадын харилцааны уламжлал шинэчлэлийн асуудлыг хөндөж хэтийн төлөвийг нь олон талаас нь харьцуулан судалсан байна.

Эрдэмтэн судлаач Г.Төмөрчулуун Монгол-Оросын харилцааны асуудлыг нэлээд өргөн дэлгэр авч үзжээ. Ингэхдээ гол төлөв XX зууны ерээд оноос хойшхи хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бууралт, өрнөлт, өнөөгийн үйл явцыг нарийвчлан системтэй авч үзсэн байна.